




Ёс зүйн дүрэм

2022 оны 7 дугаар сар



Агуулга

I Удирдах зөвлөлийн мэндчилгээ

II Оршил / танилцуулга


III Ёс зүйн дүрэм – Зорилго, цар хүрээ

1. Зорилго
2. Цар хүрээ

IV Хариуцлагын зарчмууд

V Түгээн дэлгэрүүлж, хэрэгжүүлэх нь

1. Түгээн дэлгэрүүлэх процесс
 - 1.1. Ёс зүйн дүрмийг түгээн дэлгэрүүлж, дагаж мөрдөх үүрэг – Харилцагчид
 - 1.2. Ёс зүйн дүрмийг түгээн дэлгэрүүлж, дагаж мөрдөх үүрэг – Жэй Си Дэко-гийн ажилтнууд
2. Зар сурталчилгааны эх бэлтгэлийг батлах журам
 - 2.1. Зар сурталчилгааны эх бэлтгэлийг батлах хороо, түүнтэй адилтгах процедур
 - 2.2. Зохицуулалт ба агуулгын ёс зүйн хяналт



I | Удирдах зөвлөлийн мэндчилгээ

JCDesaux Групп нь дэлхийн томоохон хотуудын олон нийтийн газар байрладаг 1 сая орчим сурталчилгааны дэлгэцийн угсралт, ашиглалт, борлуулалт маркетингийг өдөр бүр хариуцан ажиллаж байна. Гадна зар сурталчилгаа нь олон нийтийн нэг хэсэг тул Жэй Си Дэко нь харилцагчид, түншүүд болон иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сурталчилгааны байгууламжуудынхаа загвар дизайн, хэвийн ажиллагаа, засвар үйлчилгээнээс гадна дээр нь байршуулах сурталчилгааны агуулга зэрэг бүхий л зүйлст онцгой анхаарч ирсэн билээ. Ноён Жан-Клауд Дэко 1964 онд Жэй Си Дэко компанийн үүсгэн байгуулсан цагаас хойш үйлчилгээний чанар гэдэг ойлголт бидний бизнесийн гол цөм нь байсаар ирсэн билээ. Түүний алсын хараан дээр тулгуурлан, манай бизнес ёс зүйтэй, хариуцлагатай зар сурталчилгааг чухалчилсаар ирсэн бөгөөд энэ нь бидний гадна зар сурталчилгааны салбарт тэргүүлэгч, хариуцлагатай харилцаа холбооны салбарын түүчээлэгч байх хүсэл эрмэлзлэлийн нэг хэсэг юм. Бид үйл ажиллагаагаа явуулж буй улс бүхэндээ тухайн улс орны хууль тогтоомжийг дагаж мөрдөхийн зэрэгцээ компанийг үүсгэн байгуулагчийн үнэт зүйлсэд тулгуурлан өөрсдийн хэмжээнд мөрдөгдөх ёс зүйн дүрмийг боловсруулсан билээ. Энэ нь компанийн үнэт зүйлд суурилсан тодорхой зарчмуудыг тусгасан дэлхийн хэмжээний цар хүрээтэй ёс зүйн дүрэм юм. Энэ нь тус дүрмийг улс орон бүрт хэрхэн түгээх, хянах талаар зааварчилгаа, түүнчлэн тухай улс орны хэмжээнд шаардагдах мэдлэг, хариуцлагыг багтаасан болно.



II | Танилцуулга

Гадна зар сурталчилгааны салбарт дэлхийд тэргүүлэгчийн хувьд Жэй Си Дэко групп нь зар сурталчилгаагаар санхүүжигдсэн үнэ цэнтэй тохижилт, үйлчилгээг нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчид болон иргэдэд үзүүлдэг. Бид гудамжны байгууламжуудыг хүмүүсийн хэрэгцээнд нийцүүлэн, гоёмсог болгож, хотын иргэдийн тав тухыг сайжруулахын тулд загвар дизайн, угсралт, засвар үйлчилгээнд чухал ач холбогдол өгдөг. Манай зар сурталчилгааны байгууламжууд нь манай түншүүд болон оролцогч талуудыг гадуур явж байхдаа олон нийттэй харилцах боломжийг олгож, бидний үйл ажиллагаагаа явуулж буй улс орон бүрт эдийн засаг, нийгмийн үнэ цэнийг бий болгодог. Жан-Клауд Декогийн зар сурталчилгааны санхүүжилттэй үйлчилгээг иргэдэд үзүүлэх анхдагч үзэл баримтлал нь дэлхий даяар шилдэг гэдгээрээ алдартай. Түүний бий болгосон тогтвортой бизнесийн загвар нь өнөөдөр ч гэсэн татварын дарамтгүйгээр хотынхоо өнгө үзэмжийг сайжруулах боломжийг дэлхийн 80 гаруй орны иргэдэд олгосоор байна. Манай байгууламжууд дээрх зар сурталчилгаа нь дэлхийн томоохон хотуудын 150 гаруй нисэх онгоцны буудал, метро, автобус, галт тэрэг, трамвай зэрэг нийтийн тээврийн сүлжээгээр дамжуулан хүмүүст хүрдэг.

Группийн чанар, инноваци, хүсэл тэмүүллийн үнэт зүйлс нь биднийг гурван салбарт хэрхэн ажиллахыг тодорхойлдог:

- Гудамжны байгууламж
- Нийтийн тээвэр,
- Биллбоардын сурталчилгаа

Манай зар сурталчилгааны багцыг дэлхийн өнцөг булан бүрт хэдэн зуун сая хүмүүс өдөр бүр харж, харьцуулшгүй өргөн цар хүрээтэй олон нийтийн платформыг бий болгодог. Бид үйлчлүүлэгчид болон түншүүдийнхээ итгэл үнэмшлээр тэдэнтэй хамтран ажиллаж, хүмүүс болон байгаль орчинд үйлчилдэг харилцан ашигтай хөгжлийн загвараараа бахархдаг. Гадна зар сурталчилгааны салбартаа дэлхийд тэргүүлэгч хариуцлагатай компанийн хувьд үүсгэн байгуулагчийнхаа алсын хараанд тулгуурласан үйлчилгээ болон тогтвортой хөгжлийн зорилтуудыг бизнесийн нэн тэргүүнд тавьсаар ирсэн хариуцлагатай компани билээ.


JCDecaux нь бизнесийн үйл ажиллагааныхаа хүрээнд ажилтнууд, харилцагчид, ханган нийлүүлэгчид болон бусад оролцогч талуудтай холбоотой үндсэн үнэт зүйлсийг үргэлж баримталж ирсэн бөгөөд энэ нь бидний нэр хүндийн илэрхийлэл, түншүүдийн итгэлийн түлхүүр юм. Манай дэлхийн даяарх салбар нэгжүүд тухайн улс орнуудын дүрэм, журмыг дагаж мөрдөж, бидний алсын харааны нэг хэсэг болгон өөрсдөдөө илүү өндөр стандартуудыг нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.

Үүний үр дүнд, Жэй Си Дэко групп нь 1948 оны 12-р сарын 10-ны өдөр батлагдсан НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1989 оны 11 сарын 20-нд батлагдсан Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1950 оны 11-р сарын 04-ний өдөр батлагдсан Европын Зөвлөлийн Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай конвенц, 2000 оны 12 сарын 07-ны өдөр батлагдсан Европын холбооны үндсэн эрхийн дүрэм зэрэг тунхаглалын нийтлэг үнэт зүйлсийг урт хугацаанд баримтлах үүрэг хүлээсээр ирсэн билээ.

Эдгээр зарчмууд нь :

- Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө
- Худалдаа, үйлдвэрлэлийн эрх чөлөө
- Хүний нэр төр, эрхийг хүндэтгэх
- Жендэрийн тэгш байдлыг хүндэтгэх
- Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, анти-семитизм болон аливаа угсаатны бүлэг, соёлын нийгэмлэгийн гишүүнчлэл, хүйс, бэлгийн чиг хандлага, хувийн үзэл баримтлал, гүн ухааны болон/эсвэл шашны итгэл үнэмшлээр нь ялгаварлан гадуурхахаас татгалзах
- Хүүхэд, өсвөр үеийнхэнд хүндэтгэлтэй хандах
- Хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлсэн аливаа хууль бус үйлдэл, эс үйлдэхүйд уриалсан үйлдэл, хүчирхийллээс татгалзах
- Шударга ёс, үнэнч шударга байдлыг хүндэтгэх

JCDecaux-ийн ёс зүйн дүрэм нь бидний үнэт зүйлс болон дээрх зарчмуудын нийцүүлэн харилцагчийн сурталчилгааг гудамжны байгууламжууд дээр байршуулахад дагаж мөрдөх группийн бодлого, стандартыг тогтоодог. Их өөрчлөлтийн энэ цаг үед ёс зүй, хариуцлагын шаардлага урьд өмнөхөөсөө илүү хурцаар тавигдаж байна. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор, бизнесүүд үйлдвэрлэлийн процессоо өөрчилж байгальд ээлтэй тогтвортой өсөлттэй, эдийн засаг руу шилжиж байна. Үүний зэрэгцээ, хэрэглэгчид тогтвортой хөгжилрүү чиглэсэн ажил, үйлчилгээг улам чухалчилах болсон. Байгаль цаг уурын шилжилт үргэлжилж байгаа энэ үед манай байгууламжууд дээр байршуулж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний талаалх аливаа зар сурталчилгааг хариуцлагатай, ёс зүйтэй байлгахад гадна зар сурталчилгаа урьд өмнөхөөсөө илүү чухал үүрэг гүйцэтгэх болсон. Байгаль орчин, тогтвортой хөгжилд суурилсан шалгуур нь манай харилцагч, үйлчлүүлэгч нарын хувьд медиа партнераа сонгоход чухал ач холбогдолтой болж байна. JCDecaux-ийн аудитлагдсан санхүүгийн тайлагналыг дэлхий даяар (CDP, MSCI, FTSE4Good) хүлээн зөвшөөрсөн бөгөөд Групп нь нийгмийн хариуцлагатай компани гэдгээрээ уур амьсгалын өөрчлөлт, шилжилттэй холбоотой ажилд чухал үүрэг гүйцэтгэж байгаа билээ. Орон нутгийн болон дэлхийн өнцгөөс харвал манай харилцагч, үйлчлүүлэгчид гадна зар сурталчилгаанд ёс зүйтэй, хариуцлагатай сурталчилгааг чухалчлах болсон нь бидний урт хугацааны алсын хараа болон НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтуудтай (SDGs) төгс нийцэж байгаа юм. Бид сурталчилгааны гол түншүүдтэйгээ удаан хугацааны турш хамтран ажиллаж, тэдний брэндүүдийн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, гүйцэтгэж болох үүргийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилготой. Бид дотоод болон гуравдагч талын туршлага, брэндүүд болон орон нутгийн удирдлагуудын хооронд зуучлагчийн үүргээ ашиглан нийгэмд эерэг, тогтвортой нөлөө үзүүлэх хамтын санаачилга буюу «Брэнд хотжилт»-ыг тэргүүлж байна. Бид илүү тогтвортой ирээдүй рүү тэмүүлэхийн хэрээр дэлхий даяарх JCDecaux-ийн салбар компаниуд хариуцлагатай, ёс зүйтэй гадна зар сурталчилгааг бий болгоход улам чухал үүрэг гүйцэтгэсээр байх болно.




III Ёс зүйн дүрэм, Зорилго ба хамрах хүрээ

1. ЗОРИЛГО

JCDecaux-ийн ёс зүйн дүрэм нь сурталчилгааны байгууламжууд дээр байршуулах сурталчилгааны хэм хэмжээг тодорхойлсон баримт бичиг бөгөөд JCDecaux SA (Францын нийтийн хязгаарлагдмал компани) болон группын бүх компаниуд дагаж мөрдөх үүрэгтэй. JCDecaux олон улсын худалдааны танхимын (ICC) Зар сурталчилгаа, Маркетингийн харилцааны код, Зар сурталчилгааг Зохицуулах Олон Улсын Зөвлөл (ICAS), Европын Зар сурталчилгааны стандартын холбоо (EASA), Францын мэргэжлийн зар сурталчилгааны зохицуулах газар (ARPP) зэрэг байгууллагын хэд хэд кодыг ашиглан тус дүрмийг боловсруулсан бөгөөд мөн тухайн улс орны шийдвэр гаргагчдаас өгсөн зөвлөмжийг дагаж мөрдөхийг зөвшөөрдөг.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү дүрэм нь бүх сурталчилгаа/харилцаа холбооны бүхий л хэрэгсэлд хамаарна. Үүнд JCDecaux-ийн үйл ажиллагаагаа явуулж буй бүх улс орон дахь арилжааны, урамшууллын, зарлал-мэдээллийн зориулалттай зурагт хуудас, дижитал дэлгэц, баннер, гадна сурталчилгааны хэрэгсэл, түүнчлэн бүх визуал формат (PDF болон JPG), дижитал контент (mp4 формат) болон нийгмийн сүлжээ багтана. Энэхүү дүрэм нь бидний үйл ажиллагаа явуулж буй улс оронд хэрэгжиж буй дүрэм журам дээр нэмэлт байдлаар ашиглагдах зорилготой юм. Хэрэв тухайн улс орны хууль, дүрэм журам нь энэхүү ёс зүйн дүрэмтэй зөрчилдвөл JCDecaux-ийн тухайн орон нутаг дахь салбар компани нь дүрмийг үйл ажиллагаагаа явуулж буй улс орныхоо хууль журамд нийцүүлэн өөрчлөн боловсруулж, дагаж мөрдөнө.



IV | Хариуцлагын зарчмууд

Нийгмийн хариуцлага

Зар сурталчилгаа нь хүний нэр төрийг хүндэтгэх ёстой бөгөөд аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг, ялангуяа яс үндэс, нийгмийн гарал үүсэл, шашин шүтлэг, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, хүйсийн баримжаа болон/эсвэл бэлгийн чиг хандлагаар нь ялгаварлан гадуурхахыг хөхүүлэн дэмжихгүй байх ёстой.

Аливаа зар сурталчилгаа нь хүнийг доромжилж болохгүй.

Зар сурталчилгаа нь хэн нэгнийг хүйс, гарал үүсэл, нийгмийн давхарга, бэлгийн чиг баримжаа болон/эсвэл бусад өөр бусад шалгуураар ялгаварлан гадуурхаж, дорд үзэх үзэл баримтлалыг дэмжих ёсгүй. Бүр тодруулбал, зар сурталчилгаа нь хүний нийгэм дэх үүрэг, хариуцлагыг дордуулж болохгүй. Зар сурталчилгаа нь гадуурхах, үл тэвчих, хүйсээр ялгаварлах шинжтэй шууд болон шууд бус мэдрэмж төрүүлэх аливаа үг, үйлдлийг сурталчлах ёсгүй. Зар сурталчилгаа нь зөвхөн үндэслэлтэй үндэслэлээс бусад тохиолдолд айдсыг ашиглах ёсгүй. Зар сурталчилгаа нь аливаа хууль бус, зүй бус үйлдлийг өдөөж, дэмжих ёсгүй. Зар сурталчилгаа нь боловсролын болон нийгмийн үндэслэлтэйгээс бусад тохиолдолд, хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд харшлах аливаа үйлдэл, нөхцөл байдлыг сурталчлах, дүрслэх ёсгүй. Зар сурталчилгаа нь үнэн, шударга байх ёстой бөгөөд үндэслэлгүй айдас төрүүлэх аливаа мэдэгдэл, дүрслэлийг зөвшөөрөх ёсгүй. Бүх төрлийн мөлжлөг, мухар сүсгийг хатуу хориглох ёстой. All forms of exploitation and superstition must be strictly prohibited. Сурталчилж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээнд зөвтөгдөхөөс бусад тохиолдолд сурталчилгаанд шууд болон санал болгосон хүчирхийллийн аливаа үзүүлбэр, үйлдлийг оруулах ёсгүй. Ёс суртахууны болон бие махбодийн хүчирхийллийг өдөөхийг хатуу хориглоно.

Ёс зүй

Зар сурталчилгаа нь тухайн улс орон, соёлд тогтсон буюу нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээнд харшлах ямар ч дүрслэлийг харуулах ёсгүй.

Итгэл

Зар сурталчилгаа нь хэрэглэгчийн итгэлийг урвуулан ашиглах эсвэл хэрэглэгчдийн туршлага, мэдлэг дутмаг байдлыг ашиглах ёсгүй.

Шударга, үнэнч байдал

Зар сурталчилгаа нь шууд болон шууд бусаар төөрөгдүүлсэн мэдэгдэл, дүрслэлийг хориглох ёстой. Энэ нь хоёрдмол утгатай эсвэл хэтрүүлсэн агуулгад хамаарна.

Сөрөг компани́т ажил

Зар сурталчилгаа нь аливаа байгууллага, мэргэжил, хувь хүн, хэсэг бүлэг хүмүүс, бүтээгдэхүүний нэр хүндийг шударга бусаар гутааж болохгүй.

Зургийн эрх

Зар сурталчилгаа нь тухайн хүний зургийг урьдчилан зөвшөөрөлгүйгээр ашиглах ёсгүй.

Оюуны өмчийн эрх

Зар сурталчилгаа нь тодорхой шалтгаангүйгээр бусад компани, байгууллагын нэр, лого болон/эсвэл брэндийг ашиглах ёсгүй. Зар сурталчилгаа нь бусад компани/байгууллагын нэр хүнд эсвэл бусад сурталчилгааны кампанит ажилтай холбоотой нэр хүндийг шударга бусаар ашиглах ёсгүй. Зар сурталчилгаанд хэрэглэгчийг төөрөгдүүлж болзошгүй бусад сурталчилгааны кампанит ажилд орсон загвар, текст, уриа лоозон, дүрслэл, дуу хөгжим гэх мэт дуураймал зүйл байж болохгүй.

Хүүхэд ба өсвөр насныхан

Сурталчилгаа нь хүүхэд, өсвөр насныхны итгэл үнэмшил, үнэнч байдал, эмзэг байдал, туршлага дутмаг байдлыг ашиглах ёсгүй. Зар сурталчилгаа нь тухайн бүтээгдэхүүнийг ашиглахад шаардагдах ур чадвар болон/эсвэл насыг бууруулж болохгүй. Сурталчилгаа нь хүүхэд, өсвөр насныхны сэтгэл зүй, ёс суртахууны болон бие махбодид хохирол учруулахуйц ямар нэгэн мэдэгдэл, дүрслэлийг агуулж болохгүй. Зар сурталчилгаа нь тэднийг эрүүл мэнд, сэтгэлзүйн амар амгалан байдал, аюулгүй байдалд ноцтой эрсдэл учруулах нөхцөл байдал, үйл ажиллагаанд хүргэж болохгүй. Зар сурталчилгаа нь бүтээгдэхүүн, үйлчилгээг эзэмшиж буй эсэхээс үл хамааран хүүхдүүдэд бие махбод, нийгэм, сэтгэл зүйн давуу байдлыг олгох ёсгүй. Сурталчилгаа нь эцэг эхийн эрх мэдэл, үүрэг хариуцлага, дүгнэлт, дур сонирхлыг алдагдуулах ёсгүй. Зар сурталчилгаа нь тухайн улс орны нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нийгэм, соёлын үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Байгаль орчны зан үйл

Зар сурталчилгаа нь хууль бус ба/эсвэл байгаль орчинд хор хөнөөл учруулсан үйлдэл, практикийг дэмжих ёстой.


Тогтвортой хөгжил

Тогтвортой хөгжлийн ерөнхий санааг ашигласан эсвэл тогтвортой байдлын зорилгод нийцэхгүй агуулгатай зар сурталчилгаа нь үнэн зөв, үнэнч байх, бодитой, найдвартай байх зарчмуудыг дагаж мөрдөх ёстой.

1. Үнэн ба үнэнч байдал: Зар сурталчилгаа нь сурталчлагчийн үйл ажиллагааны жинхэнэ мөн чанар болон/эсвэл тэдний бүтээгдэхүүн, үйлчилгээний шинж чанарын талаар олон нийтийг хуурч мэхлэх ёсгүй.

2. Объектив байдал: Зар сурталчилгаа нь тогтвортой хөгжлийг дэмжихдээ өөрийн мессежийн пропорциональ шинж чанар, үүнтэй холбоотой сурталчлагчийн санаачилгын жинхэнэ мөн чанарыг тусгах ёстой.

3. Үнэн байдал: Зар сурталчилгаа нь бусад сурталчлагчдын удирддаг санаачилгатай харьцуулах боломжтой бол сурталчлагчийн санаачилгын онцгой шинж чанарыг илэрхийлэх ёсгүй. Зар сурталчилгаа нь нийгмийн болон хүний эрхийг зөрчиж буй хөдөлмөрийн нөхцлийг дэмжих ёсгүй.



V | Түгээн дэлгэрүүлж, хэрэгжүүлэх нь

1. Түгээн дэлгэрүүлэх процесс

1.1. Ёс зүйн дүрмийг түгээн дэлгэрүүлж, дагаж мөрдөх үүрэг – Харилцагчид

JCDecaux нь эдгээр үнэт зүйлсийг бүх оролцогч талуудтайгаа хамт сурталчлах үүрэг хүлээдэг. Үүнд JCDecaux Группийн дийлэнх хувийг эзэмшдэг компаниуд, эсвэл хамтарсан хяналттай компаниудаас гадна тэдний харилцагчид, түншүүд, хэвлэл мэдээллийн агентлагууд багтдаг. JCDecaux группийн салбар компаниуд нь энэхүү дүрмийг харилцагчиддаа бүрэн дагаж мөрдүүлэхийн тулд Борлуулалт, Үйлчилгээний ерөнхий нөхцлийг тусгасан баримт бичгүүдээ боловсруулахдаа уг журмаас иш татсан байвал зохино. JCDecaux группийн стандарттай холбоотой бүх баримт бичгийн нэгэн адил (Ёс зүйн дүрэм, Нийгмийн үндсэн үнэт зүйлсийн олон улсын дүрэм, Нийлүүлэгчийн ёс зүйн дүрэм) энэ дүрмийг Группийн олон нийтэд нээлттэй вэб сайтаас татаж авах боломжтой.

1.2. Ёс зүйн дүрмийг түгээн дэлгэрүүлж, дагаж мөрдөх үүрэг – Жэй Си Дэкогийн ажилтнууд

Энэхүү дүрмийг охин компаниудын дотоод сүлжээн дээр байршуулсан байдаг бөгөөд JCDecaux-ийн бүх ажилтнууд дагаж мөрдөх шаардлагатай. Маркетинг, борлуулалт, олон нийттэй харилцах хэлтсийнхэн, мөн ёс зүйтэй зар сурталчилгааг хариуцдаг төрийн албаныханд энэ дүрмийн талаар мэдэгдэж, дүрмийг дагаж мөрдөх шаардлагатай гэдгийг ойлгуулах ёстой.

5.2. ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ЭХ БЭЛТГЭЛИЙГ БАТЛАХ ЖУРАМ

JCDecaux Групп нь зар сурталчилгааны агентлагууд болон харилцагчдаас хүлээн авсан эх бэлтгэлийг хэрхэн хянах үйл явцыг ойлгомжтой, уялдаатай болгох үүднээс боловсруулсан дараах зөвлөмжийг ашиглах ёстой. JCDecaux группийн ёс суртахууны зар сурталчилгааг хариуцдаг хяналтын хороо нь өөрсдийн арга барилыг бодит үнэлгээнд үндэслэх ёстой. Аливаа шийдвэрийг тухайн орон нутгийн нөхцөл байдалд нийцүүлэн гаргахаас гадна энэ дүрэмд заасан Группийн нийтлэг зарчмуудыг дагаж мөрдөх нь чухал юм.

2.1. Зар сурталчилгааны эх бэлтгэлийг батлах хороо, түүнтэй адилтгах процедур

Энэхүү дүрмийн хэрэгжилтийг хангахын тулд Жэй Си Дэко Группийн салбар компаниуд дотооддоо хууль эрх зүй, борлуулалт маркетинг, тогтвортой хөгжил, олон нийттэй харилцах хэлтсийн төлөөллөөс бүрдсэн “Зар сурталчилгааны эх бэлтгэлийн хяналтын хороо”-г байгуулан ажиллаж байна. Зар сурталчилгааны хяналтын хороо нь татгалзсан, зөвшөөрсөн эсвэл засвар оруулсан эх бэлтгэлийн талаарх дэлгэрэнгүй тэмдэглэл, бүртгэл хөтөлж байх ёстой. Хороонууд журмын дагуу үйл ажиллагаагаа тогтмол тайлагнаж байх ёстой.

2.2. Агуулгын зохицуулалт, ёс зүйн хяналт


Зар сурталчилгааны эх бэлтгэлийн хяналтын хороо нь тухайн орныхоо зар сурталчилгааны тухай хуулийн талаар, ялангуяа сурталчилахыг хориглосон, хязгаарласан бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний талаар мэдлэгтэй байх ёстой. Үүнд: архи, тамхи, мөрийтэй тоглоом, хоол хүнс, хүүхдэд зориулсан хязгаарлалттай бүтээгдэхүүн, улс төрийн шинжтэй сурталчилгаа, хүмүүсийн дүр төрх багтаж болно.

Харилцагчтай зар сурталчилгааны гэрээ байгуулахаас өмнө харилцагчийн байршуулах зар сурталчилгааны эх бэлтгэлийг хянан шалгаж байвал зохино. Харилцагчийн зар сурталчилгааны эх бэлтгэл нь холбогдох хууль журам болон энэхүү ёс зүйн дүрэмд нийцэж буй эсэх дээр үнэлэлт дүгнэлт өгнө. Хяналтын хороо нь тусгай зохицуулалт бүхий зар сурталчилгааны ангилалд багтдаг бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх аливаа зар сурталчилгааг холбогдох дүрэм журамд нийцүүлэх үүднээс харилцагчид тухайн сурталчилгааны агуулгыг өөрчлөх боломжийг олгох, улмаар засвар оруулсан эх бэлтгэлийг хүлээн авах эцсийн хугацааг зааж өгөх ёстой. Борлуулалтын хэлтэс тухайн зар сурталчилгааны эх бэлтгэлийг “Хяналтын хороо”-руу илгээж агуулгыг (дүрслэл, санаа, контекст гэх мэт) нь хянуулж, батлуулах ёстой.

Энэ нь дараах үр дүнгүүдийн аль нэгэнд хүргэнэ.

- Шуут батлах
- Тодорхой нөхцөлтэйгээр батлах – Хянагдаж буй зар сурталчилгааг байршуулах, цацах шийдвэрийг тухайн салбарын борлуулалтын хэлтэс гаргах ёстой.
- татгалзах – Энэ тохиолдолд тухайн зар сурталчилгааг байршуулахгүй эсвэл цацахгүй гэсэн шийдвэрийг зөвхөн тухайн салбарын гүйцэтгэх удирдлагын баг хүчингүй болгох үндэслэлтэй шийдвэр гаргаж болно.





Ёс зүйн дүрэм

/гудамжны дижитал дэлгэцүүд/

2022 оны 7 дугаар сар



JCDecaux